БАТЛАВ
МОНГОЛЫН ТАЕКВОНДОГИЙН ХОЛБООНЫ
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Н.ЭРДЭНЭБААТАР

ОЛИМПЫН ТАЕКВОНДОГИЙН НАСАНД ХҮРЭГЧ, МАСТЕР, ПАРАТАЕКВОНДОГИЙН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН ЗААВАР

ТЭМЦЭЭНИЙ ЗОРИЛГО:

- Таеквондогийн спортыг сурталчлах
- Тив, дэлхийн, олон улсын тэмцээн, наадамд өрсөлдөх тамирчдын ур чадварыг нэмэгдүүлэхэд оршино
- 2027 оны 5 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд Япон улсад зохион байгуулагдах Дэлхийн мастерын наадамд эх орноо төлөөлөн оролцох тамирчныг сонгон шалгаруулах
- 2027 оны 7 дугаар сарын 7-13-ны өдрүүдэд Казахстан улсын Астана хотноо зохион байгуулагдах Насанд хүрэгчдийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд эх орноо төлөөлөн оролцох тамирчныг сонгон шалгаруулах

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

Зохион байгуулагч	**Монголын таеквондогийн холбоо**
Холбоо барих утас	7015-5500
Имэйл	mongoliataekwondo@gmail.com
Хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Спортын төв ордон

ТӨЛӨВЛӨГӨӨТ ХУВААРЬ:

Огноо	Хөтөлбөр	Байршил
11 сарын 1-9	Бүртгэл	www.mongol-taekwondo.com
11 сарын 15	Техникийн зөвлөгөөн	Спортын төв ордон
11 сарын 15-16	Жин үзэлт	
11 сарын 16-17	Тэмцээн	

- ❖ Бүртгэл хаагдсаны дараа тэмцээний дэлгэрэнгүй хуваарь нийтэд зарлагдах ба тэмцээнд оролцогчдын тооноос хамаарч өдөрт өөрчлөлт орж болзошгүй.

ШААРДЛАГА:

Тэмцээнд оролцогч **Тамирчдад** Монголын таеквондогийн холбооны дүрэм, журмын дагуу дараах шаардлага тавигдана.

1. Оролцогч тамирчин Куккивон болон Монголын таеквондогийн холбооны ямар нэг зэрэг, дантай байна. Тэмцээний үеэр зөвхөн тухайн бүсээ бүсэлнэ
2. Тэмцээнд оролцогч тамирчин бүр таеквондогийн ёс, дэг журмыг чанд баримтлах, хувийн ариун цэврийг дээд зэргээр хангасан байх шаардлагатай. Үүнд: гар, хөлийн хумсыг засаж, элдэв бөгж, хүзүүний зүүлт зэргийг хэрэглэхгүй байх.
3. Тамирчид бээлий, шилбэ, шуу, шүд /өнгөгүй тунгалаг эсвэл цагаан өнгөтэй/, эмзэг эрхтний хамгаалалт болон KPNP цахим мэдрэгчтэй оймсыг бэлдэж ирэх шаардлагатай

Багт тавигдах шаардлага:

1. Тэмцээнд оролцох байгууллага нь Монголын таеквондогийн холбооны албан ёсны гишүүн байгууллага байна
2. Оролцогч байгууллага нь татвар, хураамжийн үлдэгдэл тооцоогүй байх
3. Нэг байгууллагаас оролцох тамирчны тоонд хязгаарлалт тавихгүй

Дасгалжуулагчид тавигдах шаардлага:

1. Монголын таеквондогийн холбооны дасгалжуулагчийн В зэрэгтэй эсвэл олон улсын дасгалжуулагчийн эрх бүхий дасгалжуулагч тамирчдыг дэвжээнд авч гарах эрхтэй
2. Хагас шигшээ болон шигшээ тулааны үеэр дасгалжуулагчид албаны хувцас өмсөх шаардлагатай
3. Тэмцээнд оролцохоор хүрэлцэн ирэх, буцах замд болон тэмцээний үеэр хариуцсан тамирчдынхаа аюулгүй байдалд хяналт тавих нь тухайн багийн дасгалжуулагчийн үүрэг
4. Тэмцээний үеэр дасгалжуулагч нь ямар ч төрлийн малгай өмсөхийг хориглоно

1. ЖИНГИЙН ДАРААЛАЛ:

Насанд хүрэгч (16 болон түүнээс дээш) 2010 оноос өмнө төрсөн тамирчид:

Эр		Эм	
-54 кг	54 кг хүртэлх	-46 кг	46 кг хүртэлх
-58 кг	54 кг жингээс 58 кг жингийн хооронд	-49 кг	46 кг жингээс 49 кг жингийн хооронд
-63 кг	58 кг жингээс 63 кг жингийн хооронд	-53 кг	49 кг жингээс 53 кг жингийн хооронд
-68 кг	63 кг жингээс 68 кг жингийн хооронд	-57 кг	53 кг жингээс 57 кг жингийн хооронд
-74 кг	68 кг жингээс 74 кг жингийн хооронд	-62 кг	57 кг жингээс 62 кг жингийн хооронд
-80 кг	74 кг жингээс 80 кг жингийн хооронд	-67 кг	62 кг жингээс 67 кг жингийн хооронд
-87 кг	80 кг жингээс 87 кг жингийн хооронд	-73 кг	67 кг жингээс 73 кг жингийн хооронд
+87 кг	87 кг жингээс дээш жинтэй тамирчид	+73 кг	73 кг жингээс дээш жинтэй тамирчид

Мастер (29 болон түүнээс дээш) 1997 оноос өмнө төрсөн тамирчид:

Эр		Эм	
-58 кг	58 кг хүртэлх	-49 кг	49 кг хүртэлх
-68 кг	58 кг жингээс 68 кг жингийн хооронд	-57 кг	49 кг жингээс 57 кг жингийн хооронд
-80 кг	68 кг жингээс 80 кг жингийн хооронд	-67 кг	57 кг жингээс 67 кг жингийн хооронд
+80 кг	80 кг жингээс дээш жинтэй тамирчид	+73 кг	67 кг жингээс дээш жинтэй тамирчид

2027 онд зохион байгуулагдах “Дэлхийн мастерын наадам” болон “Насанд хүрэгчдийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн”-тэй уялдуулан зөвхөн энэ удаагийн тэмцээний насны ангилалд өөрчлөлт оруулсан болно. Мастер ангилалд хамаарах тамирчин нь өөрийн хүсэлтээр насанд хүрэгчдийн ангилалд оролцох боломжтой.

Паратаеквондо (16 болон түүнээс дээш) 2010 оноос өмнө төрсөн тамирчид:

Эр		Эм	
-63 кг	63 кг хүртэлх	-52 кг	52 кг хүртэлх
+63 кг	63 кг жингээс дээш жинтэй тамирчид	+52 кг	52 кг жингээс дээш жинтэй тамирчид

2. БҮРТГЭЛ:

1. Бүртгэлийг цахимаар хийх ба Монголын таеквондогийн холбооны албан ёсны бүртгэлийн систем болох www.mongol-taekwondo.com хаягаар бүртгүүлнэ.

2. Оролцогчийн хураамжийг зөвхөн цахимаар төлнө.

I. Бүртгэлийн хугацаа: 2026 оны 11 сарын 9-ний 23:00 цаг хүртэл
- Тамирчны дэвжээний хураамж 80,000 төгрөг (наян мянга) төгрөг

Хоцорсон бүртгэл: 2026 оны 11 сарын 10-ны 17:00 цаг хүртэл

- Тамирчны дэвжээний хураамж 120,000 төгрөг (нэг зуун хорин мянга) төгрөг

2026 оны 11 сарын 10-ны 17:00 цагаас хойш ямар ч тохиолдолд бүртгэлд өөрчлөлт оруулахгүй.

3. Мастер болон паратаеквондогийн ангилалд оролцох тамирчид хүчинтэй лицензтэй байхыг шаардахгүй.

3. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ:

1. Хувь тамирчин:

Жин тус бүрд 1-р байр нэг, 2-р байр нэг, 3-р байр хоёр тамирчин шалгаруулан шагнаж урамшуулна.

2. Баг:

Багийн дүнг медалийн чанараар дүгнэнэ. (зөвхөн насанд хүрэгчдийн ангилалд)

Багийн дүнгээр эрэгтэй, эмэгтэй ангилалд эхний гурван байр эзэлсэн багуудыг цом, медалиар шагнаж урамшуулна.

3. Шилдэг дасгалжуулагч:

Эрэгтэй 1 / Эмэгтэй 1 дасгалжуулагчийг тус тус шалгаруулан шагнана.

4. Шилдэг тамирчин:

Эрэгтэй 1 / Эмэгтэй 1 тамирчинг тус тус шалгаруулан шагнана.

5. Шилдэг шүүгч:

Тэмцээний шилдэг шүүгчээр 1 шүүгчийг шалгаруулан шагнаж урамшуулна.

4. ӨМСГӨЛ:

- Монголын таеквондогийн стандартад нийцсэн өмсгөл өмсөн тэмцээнд оролцох шаардлага тавигдах хэдий ч багийн нэр, логог /ивээн тэтгэгчийн/ тулааны өмсгөл болон жигдрэлийн хувцсан дээр хадахыг зөвшөөрнө.

5. БАГИЙН АХЛАГЧДЫН УУЛЗАЛТ БОЛОН СУГАЛАА

1. Багийн ахлагч нар 11-р сарын 15-ны өдөр хуралдана.
2. Багийн ахлагчдын уулзалтад тэмцээнд оролцох багууд төлөөллөө оролцуулах үүрэгтэй.

6. ЖИН ҮЗЭЛТ

1. Оролцогчдын үндсэн жинг 11-р сарын 15,16-ны өдөр үзнэ.
2. Жин тус бүрд заасан жиндээ багтах орох хэрэгтэй ба заасан жингээс 100 гр илүү жинтэй байх тохиолдолд жиндээ орж чадахгүй хасагдана. Жиндээ орж чадаагүй тамирчин дээд жиндээ орж болохгүй буюу зөвхөн мэдүүлэгт өгсөн жиндээ орох шаардлагатай.
3. Тамирчид тэмцээнтэй өдрийн өглөө хяналтын жинг санамсаргүй түүврийн аргаар үзнэ. /нэмэх жингээс бусад жингүүдийн хувьд/
4. Хяналтын жинг тухайн жинд оролцож буй тамирчдын тоонд тохирсон тамирчдыг санамсаргүй байдлаар сонгон үзнэ. Жинг 5% нэмэгдэлтэйгээр тооцно.

Жинд хамаарах тамирчдын тоо	Хяналтын жин үзүүлэх тамирчдын тоо
32 ба түүнээс дээш тамирчин	Нийт тамирчдын 20%
17-32	6
9-16	4
4-8	2
4 хүртэлх тамирчин	0

- ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО -